МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 07 сарын 02 өдөр Дугаар А/380 Есенбулаг сум

Аймгийн хариуцлагатай эргүүл жижүүр томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.9, 32.1.10 дахь заалт, аймгийн Онцгой комиссын 8 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2235, Их Монгол Улсын 820, Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээн мандуулсаны 115, Ардын хувьсгалын 105 жилийн жилийн ой, Хантайшир уулын аймгийн 103 жилийн ойн баяр, амралтын өдрүүдэд ажиллах аймгийн хариуцлагатай эрүүл жижүүрийг томилсугай.

2.Аймгийн цахилгаан, усан хангамж, сумдын болон онцгой объектуудын хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах аймгийн хариуцлагатай жижүүрийн хуваарийг нэгдүгээр, жижүүрийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Аймаг, сумдын удирдлага, ард иргэдэд цаг агаарын аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг тогтмол хүргэж, сумдын онцгой комисс, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн удирдах бүрэлдэхүүнийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Онцгой байдлын газар (хурандаа Ц.Лувсанжамц), Ус, цаг уур, орчны шинжилгээний төв (Н.Алтантуяа)-д тус тус даалгасугай.

4.Баяр наадмын өдрүүдэд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах нэгдсэн болон тусгай арга хэмжээг зохион байгуулж, ард иргэдийг амгалан тайван байх нөхцөлийг хангуулж ажиллахыг Цагдаагийн газар (хурандаа Д.Бүрэнбаатар)-т даалгасугай.

5.Аж ахуйн нэгж, байгууллагын аюулгүй байдал, хэвийн үйл ажиллагаанд хяналт тавих эргүүл, жижүүрийг томилон ажиллуулж, Онцгой байдлын газрын

8000010706

77480101 тусгай дугаарын утсанд цаг үеийн холбогдолтой мэдээ, мэдээллийг өдөр бүрийн 09:00, 14:00, 20:00 цагт, яаралтай мэдээ, мэдээллийг тухай бүр нь өгч ажиллахыг сумдын удирдлага, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

6.Баяр наадмын өдрүүдэд аймгийн хариуцлагатай жижүүрүүд томилгоот хугацаанд аймгийн онц чухал объектыг өдөрт хоёроос доошгүй хугацаанд шалгаж, илэрсэн зөрчил, өгсөн үүрэг даалгаврыг тэмдэглэлээр баталгаажуулж ажиллахыг үүрэг болгосугай.

7.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 2026 оны
07 дугаар сарын 02-ны өдрийн А/328 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН АЖИЛЛАХ ХУВААРЬ

Он, сар, өдөр	Ерөнхий жижүүрийн нэрс	Албан тушаал	Жижүүрийн хуваарь	Утсаны дугаар
2026.07.06	Д.Бүрэнбаатар	Цагдаагийн газрын дарга, хурандаа	09:00-09:00	88115839
2026.07.07	Ц.Лувсанжамц	Онцгой байдлын газрын дарга, хурандаа	09:00-09:00	88099342
2026.07.08	Н.Эрдэнэ-Очир	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга	09:00-09:00	99096246
2026.07.09	Л.Хаш-Эрдэнэ	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга	09:00-09:00	99072865
2026.07.10	Ч.Батзориг	Улаан загалмайн хорооны дарга	09:00-09:00	99141277
2026.07.11	Л.Жамбалсүрэн	341 дүгээр ангийн захирагч, дэд хурандаа	09:00-09:00	88107746
2026.07.12	А.Алтанхуяг	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга	09:00-09:00	99016669
2026.07.13	М.Насанбат	Аймгийн ЗДТГ-ын дарга	09:00-09:00	99996696
2026.07.14	Д.Чинзориг	Бүс орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга	09:00-09:00	99075990
2026.07.15	Б.Цэдэвсүрэн	"Алтай-улиастайн цахилгаан түгээх сүлжээ"ТӨХК-ны захирал	09:00-09:00	99011480
2026.07.16	Э.Баттөр	Тагнуулын хэлтсийн дарга	09:00-09:00	99080233
2026.07.17	О.Баатарчулуун	Эрүүл мэндийн газрын дарга	09:00-09:00	99082710
2026.07.18	Ж.Очир	Хүнс, хөдөө, аж ахуйн газрын дарга	09:00-09:00	99037960
2026.07.19	Д.Батмагнай	Байгаль орчны газрын дарга	09:00-09:00	86994444
2026.07.20	Н.Шинэбаяр	Цэргийн Штабын дарга	09:00-09:00	89113870

_ oOo _

Аймгийн Засаг даргын 2026 оны
07 дугаар сарын 02-ны өдрийн А/388 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН ЕРӨНХИЙ ЖИЖҮҮРИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

1.Аймгийн ерөнхий жижүүр цаашид /ерөнхий жижүүр/ гэх нь Онцгой байдлын газар дээр төвлөрч 24 цагаар үүрэг гүйцэтгэнэ.

2.Ерөнхий жижүүрүүд үүрэг гүйцэтгэсэн хугацаандаа дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлж, дараагийн эргүүлд дараа өдрийн 09:00 цагт ажлаа албан ёсоор хүлээлгэн өгнө.

3.Улсын онц чухал объект, үйлчилгээний байгууллагуудын хэвийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, тухайн байгууллагын дарга нартай байнгын холбоотой байж, шаардлагатай тохиолдолд шуурхай зөвлөгөөн хийж болно.

4.Эргүүлээр ажиллах хугацаанд гэмт хэргийн шинж чанартай асуудал илэрвэл Цагдаагийн байгууллагад шуурхай мэдэгдэж, зохих арга хэмжээг авна.

5.Аймгийн ерөнхий жижүүр нь аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын орлогч, Онцгой байдлын газрын даргад тогтмол мэдээлэл өгч, үүрэг чиглэл авч ажиллана.

6.Аймгийн төвийн байгууллага, аж ахуйн нэгжийн хариуцлагатай эргүүл жижүүрийг ерөнхий удирдлагаар хангаж, үүрэг чиглэл өгнө.

7.Ажлын шаардлагаар холбогдох байгууллагын даргад мэдэгдэн мэргэжлийн хүн, хүчийг дайчлан ажиллуулж болно.

8.Ерөнхий жижүүрийн ажиллах хугацааны унаа, шатахууны зардлыг тухайн байгууллагаас хариуцна.

9.Иргэдээс гаргасан санал, хүсэлт, гомдлыг аймгийн Шуурхай штабын 77480101 дугаарын утсаар тухай бүр нь мэдэгдэж, шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулна.

10.Байгууллага, аж ахуйн нэгжүүд ерөнхий жижүүрийн шаардсан мэдээг цаг хугацаанд нь гаргаж өгөх үүрэгтэй.

11.Томилгоот жижүүрүүд албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн, захирамжийн хэрэгжилтийг хангаагүй тохиолдолд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцно.

_ oOo _